МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597) **DOI: 10.22353/ms20234705**

МОНГОЛ ХЭЛНИЙ АНХАН ШАТНЫ АНГИД СУРАЛЦАЖ БУЙ ГАДААДЫН СУРАЛЦАГЧИЙН ҮГИЙН САНГИЙН МЭДЛЭГИЙГ ТОГТООХ НЬ

Б.Баяртуул

Түлхүүр үг: монгол хэл, үгийн сан, хэлний мэдлэгийн түвшин, хоёрдогч хэл

Монгол Улсын Их Сургуульд 1952 оноос 1971 он хүртэл 29 гадаадын иргэн монгол хэлний ангид суралцаж төгссөн[1] нь Монгол Улсын хэмжээнд монгол хэлийг хоёрдогч хэл болгон заах эхлэл суурь болсон бөгөөд МУИС-ийн ректорын 1971 оны 6-р сарын 10-ны өдрийн 230 тоот тушаалаар Хэл бичгийн факультетад гадаад оюутны сургалт хүмүүжлийн асуудлыг дагнан хариуцаж байх монгол хэлний тэнхим байгуулж, 1971-1972 оны хичээлийн жилд ЗХУ (хуучнаар) БНАВУ, Энэтхэг, Болгар, Унгар, Герман, Польш зэрэг орны 20 орчим оюутантай монгол хэлний бэлтгэл ангийн сургалтыг албан ёсоор эхлүүлж байжээ (Баттулга; Баяртуул, 2021). Энэ цаг үеэс эхлэн монгол хэлийг хоёрдогч хэл болгон заан сургах ажил эрчимтэй хөгжиж, энэ талаарх эрдэм шинжилгээний өгүүлэл, ном, сурах бичиг, гарын авлага олноор хэвлэгдэн гарчээ. Хэл шинжлэлийн салбар ухаанд ч хүүхдийн хэлний судлал, эх хэлээ гадаад/хоёрдогч хэл болгон заах, сургах онол, арга зүйн асуудлыг хэрэглээний хэл шинжлэлийн нэгэн чухал салбар хэмээн үзэж хөгжүүлсээр байна.

Аливаа хэлийг сурахад хамгийн түрүүнд үгийн сангийн мэдлэг хамгийн чухал (Norbert Schmitt, 2008:2) бөгөөд хэлний ярих, сонсох, бичих, унших чадваруудын нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Үгийн сангийн мэдлэг нь хэлийг хэрэглэх боломж олгодог бол хэлийг хэрэглэснээр үгийн сангийн баялаг нэмэгддэг байна. Гадаад хэл ялангуяа дэлхий нийтэд түгээмэл англи хэлний тухайд авч үзвэл, гадаадын суралцагч дунджаар 3000-5000 үг мэдвэл зохилтой бөгөөд үүнээс ярьж бичихэд 2000-3000 үгийг хэрэглэнэ. Тиймээс суралцагч хамгийн олон давтамжтай 3000 гаруй үгийг юуны түрүүнд мэдэх хэрэгтэй бөгөөд дараа нь цөөн давтамжтай үгсийг бие даан сурах боломжтой болно (Paul Nation, 1993).

Энэ мэтээр бусад хэлэнд гадаадын суралцагчийн сурах үгийн сангийн тоо хэмжээг тогтоон тодорхойлсон судалгаа арвин хийгдсэн байдаг бол монгол хэлний тухайд энэ талын судалгааны ажил хомс байгаа юм. Тиймээс бид монгол

[1] МУИС-ийн архивт хадгалагдаж байгаа “Хэлбичгийн факультетын Монгол хэлний тэнхимийн товч түүх” 1-р тал.

хэл сурч буй гадаад оюутны үгийн сангийн хэмжээг тогтоох буюу монгол хэлээр чөлөөтэй харилцахад хэдэн үг мэдвэл зохих асуудлыг монгол хэлний анхан шатны хэмжээнд авч үзэн тодорхойлохыг оролдсон болно.

Аливаа хэлний сонсох, ярих, унших, бичих гэсэн дөрвөн чадварыг хөгжүүлэх суурь нь үгийн сангийн мэдлэг юм. Өөрөөр хэлбэл,

- Үгийн утгыг мэдэхгүйгээр уншиж ойлгохгүй
- Үгийн утгыг мэдэхгүйгээр сонсож ойлгохгүй
- Үгийн утгыг мэдэхгүйгээр харилцан ярилцахгүй
- Үгийн утгыг мэдэхгүйгээр зохион бичихгүй
- Үгийн утгыг мэдэхгүйгээр хэл зүйн дүрмийг ойлгохгүй болно.

Орчин үеийн хэл эзэмших онолын чиглэлийн судалгаанаас үзвэл, төрөл бүрийн эхийг уншиж ойлгохын тулд ойролцоогоор 8000-9000 үг хэрэгтэй бөгөөд 8000-9000 үг мэддэг байхад сонины нийтлэл хийгээд уран зохиолын бичвэрийн агуулгыг 98 хувь ойлгоно (Hirsh and Nation, 1992) гэж үзжээ.

Мөн "Европын олон хэлний суурь хөтөлбөр"-ийн хэлний түвшин бүрийн эзэмшвэл зохих үгийн жагсаалтыг авч үзвэл,

- A1 түвшинд 500 үг
- A2 түвшинд 1000 үг
- B1 түвшинд 2000 үг
- B2 түвшинд 4000 үг
- C1 түвшинд 8000 үг
- C2 түвшинд 16000 үг мэдвэл зохино (The CEFR Levels)[2] гэжээ.

Хэрэв 1000 үг мэддэг бол та өдөр тутмын харилцааны (хэт мэргэжлийн биш бол) 80 хувийг ойлгож чадна (Hirsh and Nation, 1992). Хэрэв 3000 үг мэддэг бол энгийн эхийн 95 хувийг, мөн ихэнх зохиол, өгүүллийн ерөнхий санааг ойлгоно (Hazenberg and Hulstijn, 1996). Үүнд, ерөнхийлөн ойлгох чадвар, бүрэн ойлгох чадварыг ялгаж үзэх хэрэгтэй гэдгийг анхаарах хэрэгтэй. Харин 5000 үг мэддэг бол энгийн эхүүдийн 98 хувийг ойлгож (Nation and Laufer, 1996) төвөггүй харилцах чадвартай болох ч санаа бодлоо илэрхийлэх, мэргэжлийн үг хэллэг бүхий харилцааны орчинд зарим бэрхшээлтэй тулгарна. 10000 үг мэддэг бол төрөл бүрийн эхийг 99 хувь ойлгоно (Nation, 1990; Laufer, 1997). Тухайн хэлнийхээ баялаг үгийн сангийн мэдлэгтэй байх нь суралцагч өөрийгөө чөлөөтэй ойлгуулах төдийгүй хэрэв төв аялгуугаар нь ярьж чаддаг бол унаган хэлтнээс ч дутахгүй тэр хэлийг эзэмшсэн байна гэж үзнэ. Тиймээс хэл сурахад тавигдах тэргүүний зорилт бол үгийн сангийн мэдлэг юм (N.Schmitt, 2010).

Дэлхий дахинд хамгийн түгээмэл хэрэглэдэг англи хэлний үгийн жагсаалт бол "A General Service List of English Words"[3] бөгөөд анх Майкл Вэст 2000 үг бүхий энэхүү жагсаалтыг гаргаж байжээ. Түүнээс хойш 1995 онд Жон Бауман, Брэнт Куллиган нар нэмж сайжруулсан хувилбарыг гаргасан бол саяхан Брэнт Куллиган, Чарльз Браун, Жозеф Филлипс нар сүүлийн хувилбарыг нэмэн засварлаж гаргасан үгийн жагсаалтаа "New General Service List" гэж нэрлэжээ. Тэд олон төрлийн эхэд хамгийн олон давтамжтай тохиолдож байгаа үгсийг

[2] CEFR: https://www.coe.int/en/web/common-european-framework-reference-languages/level-descriptions

[3] Vocabulary: Design, Acquisition and Pedagogy edited by Norbert Schmidt and Micheal McCarthy. 1997

түүвэрлэж хөмрөгөө бүрдүүлсэн байна. Жишээ нь: дуртай, чадна, учраас, зогсох, зөвшөөрөх гэх мэт. Англи хэлний хувьд ерөнхий, өдөр тутмын, энгийн харилцаанд 2000 үгийг мэдэхэд хангалттай гэж үздэг. Тиймээс тодорхой чиглэлээр сурахын өмнө ерөнхий хэрэглээний 2000 үгийг мэддэг байх ёстой[4] гэсэн шаардлагыг тавьдаг ажээ.

Нэйшн /Nation/ (2001) аливаа хэлийг сурах, сургахад үгийн хэлбэр, утга, хэрэглээг ойлгож эзэмших явдал маш чухал гэдгийг онцолжээ. Энэ мэтээр үгийн санг тусгайлан судалдаг олон эрдэмтэн үгсийн сангийн мэдлэг нь уншиж ойлгох чадвар болон хэлний ерөнхий чадамжийг тодорхойлох гол үзүүлэлт болохыг онцолжээ.

Монгол хэлийг гадаад хэл болгон суралцагчдын хувьд үгийн сангийн цогц, тогтолцоотой мэдлэгтэй болох нь өдөр тутмын харилцааны янз бүрийн орчин нөхцөлд саадгүй харилцах үндэс суурь болох төдийгүй төрөл бүрийн эх бичвэр, харилцаа ярианы болон соёлын өөр орчинд нэвтэрч ойлголцоход түлхүүр болно.

Бид БШУЯ-ны захиалга, ШУТС-ийн санхүүжилттэйгээр хэрэгжүүлсэн "Монгол хэлний стандарт шалгалт, тест, программ хангамжийн тогтолцоо боловсруулах нь"[5] төслийн хүрээнд монгол хэлний анхан шатанд суралцагчийн үгийн сангийн хэмжээг тогтоосон бөгөөд тус өгүүлэлд уг судалгааны ажлын үр дүнг танилцуулна. Үүнд, европын болон дэлхийн бусад оронд түгээмэл хэрэглэж буй "Европын олон хэлний суурь хөтөлбөр"-ийн үндсэн зарчмыг баримталж, хятад, япон, солонгос, англи, орос, герман зэрэг хэлний түвшин тогтоох шалгалтын стандарт баримт бичгийг харьцуулан үзэж, арга зүйн үндэс болгов. Ингэхдээ монгол хэлний мэдлэг чадварын түвшнийг анхан, дунд, ахисан гурван шаттай байхаар тогтоож, шат бүр нь 2 түвшинтэй буюу нийт зургаан түвшин байна гэж үзэв. Тухайлбал, анхан шат М1, М2 түвшинтэй, дунд шат М3, М4 түвшинтэй, ахисан шат М5, М6 түвшинтэй байна. М гэдэг нь "монгол хэл" гэх үгийн товчлол болно (Д.Заяабаатар нар. 2023).

Монгол хэлийг хоёрдогч болон гадаад хэл болгон сурч буй гадаад суралцагчид зориулан аль түвшинд ямар төрлийн хэдэн үгийг мэдсэн байвал зохистойг судалгааны үр дүнд тулгуурлан тодорхойлох нь сургалт, судалгааны дараах ач холбогдолтой. Үүнд,

1. Эзэмшвэл зохих үгийн сангийн жагсаалт нь суралцагчийг тодорхой сэдэл тэмүүлэлтэйгээр төвлөрөн суралцахад эерэгээр нөлөөлдөг.
2. Эзэмшвэл зохих үгийн жагсаалтыг тодорхой болгосноор тухайн түвшний хүрээнд юунаас эхлэн суралцах нь суралцагчид ойлгомжтой байдаг.
3. Монгол хэлийг гадаад хэл болгон суралцагчдад үгийн сангийн мэдлэгээ баяжуулж нэмэгдүүлэхийг үргэлж эрмэлзэж байдаг боловч хэрхэн тогтолцоотойгоор сурах, ингэхдээ ямар судалгааны бүтээл, гарын авлагыг эх хэрэглэгдэхүүнээ болгох талаар баримжаагүй байдаг. Харин эзэмшвэл зохих үгийн жагсаалтыг түвшин бүрээр тодорхой гаргаж өгснөөр дээрх асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэгтэй болно.
4. Эзэмшвэл зохих үгийн жагсаалтыг баримжаалан тухайн эхэд гарч байгаа

[4] https://www.eapfoundation.com/vocab/general/ngsl/

[5] "Монгол хэлний стандарт шалгалт" инновацийн төсөл. Төслийн удирдагч Д.Заяабаатар. Санхүүжүүлэгч: Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Сан, (2021-2023).

үгийн чухал, чухал бусыг тодорхойлж болно. Тиймээс оюутанд ч, багшид ч чухал гэж үзсэн үгэнд анхаарлаа хандуулж, системтэй сурах, сургахад ач тустай.

5. Эзэмшвэл зохих үгийн жагсаалтыг ашигласнаар суралцагч өөрийнхөө түвшнийг өөрөө үнэлэн тогтоох боломжтой болно. Ингэснээр хэдий хугацаанд хэчнээн үг сурахаа зорилт болгон дэвшүүлж, үгийн сангийн мэдлэгээ сайжирч буй эсэхийг баримжаалж болно.

6. Багш хичээлийн агуулга хөтөлбөрөө боловсруулахдаа тухайн түвшний эзэмшвэл зохих үгийн сангийн жагсаалтыг ашигласнаар сургалтын үр дүн жигд, хүртээмжтэй, үр дүнтэй болно.

7. Улмаар багшийн хичээлийн агуулгад тохиолдоогүй боловч тухайн сурч буй түвшиндээ эзэмшвэл зохих үгсийн жагсаалтаа ашиглан суралцагч өөрөө бие даан нөхөн сурах боломжтой.

Бид монгол хэлийг хоёрдогч хэл болгон суралцаж буй гадаадын суралцагчийн анхан шатны ангид эзэмшвэл зохих үгсийн жагсаалтыг боловсруулан гаргахдаа дараах зарчмыг баримтлан боловсруулав. Үүнд,

- Үгийн давтамжийн судалгаа хийв. Үүнд, Ерөнхий боловсролын сургуулийн монгол хэлний сурах бичгүүд, гадаадын суралцагч нарт зориулсан монгол хэлний төрөл бүрийн сурах бичгүүд, өдөр тутмын сонин зэрэг өргөн хүрээг хамарсан хэрэглэгдэхүүн цуглуулж улмаар эдгээрт хамгийн өндөр давтамжтай тохиолдож буй үгсийг орчин үеийн тооцооллын аргаар гаргав. Улмаар тооцоолж гаргасан өндөр давтамжтай үгсийг хянан нягталж ангилав.
- Өдөр тутмын харилцаанд түгээмэл тохиолддог харилцааны орчин нөхцөл болон нийтлэг сэдвүүдийн жагсаалт гаргаж, тухайн сэдэвтэй уялдуулж үгийн жагсаалтыг бүрдүүлэв.
- Монгол ахуй, ёс заншилтай холбоотой үгс буюу гадаад улс орны ахуй, соёлд тохиолддоггүй, монгол соёл сэтгэлгээний онцлогийг тусгасан үгсийн жагсаалтыг хийв.
- Өндөр давтамжтай гарсан үгсийг ямар ямар сэдэвтэй уялдаж болохыг тогтоов.
- Мөн ярианы болон бичгийн хэлэнд хоёуланд нь хэрэглэглэх байдлыг тэгш харгалзан үзэв.
- Үгийг үгсийн аймгаар ангилж тоолов. Жишээ нь: хар-тэмдэг нэр (хар цагаан), хар-үйл үг (үзэж харах) гэх мэт.

Бид анхан шатанд өдөр тутмын харилцаанд хэрэглэгдэх сэдвийн хүрээг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Мэндлэх: өдөр тутмын мэнд, дөрвөн улирлын мэнд
- Танилцах: өөрийгөө танилцуулах, юу хийдэг, хаана сурдаг талаар
- Манай анги: ангийн эд хогшлыг нэрлэх, заах
- Манай гэр бүл: аав ээж, ах эгч дүү, найз нөхөд, хүүхэд, эхнэр нөхрөө танилцуулах
- Тоо, цаг хугацаа: тоо тоолох, цаг товлох, цаг асуух, хариулах
- Төрсөн өдөр: төрсөн он, сар, өдөр хэлэх
- Гэрийн хаяг, утасны дугаар
- Улс үндэстэн: таван тивийн улс, тэдгээрийн нэр
- Ажил мэргэжил: ажил мэргэжлийн үг хэллэг, хэн юу хийдэг тухай

- Ажлын өдөр: өдөр тутам хийдэг ажил, хичээл, спорт
- Ресторан: төрөл бүрийн хоолны нэр, хоол захиалах, төлбөр тооцоо хийх
- Дэлгүүр: хоол хүнс, хувцас хунар худалдаж авах, өнгө, хэмжээ асуух
- Газар орон асуух, зүг чиг заах
- Нийтийн тээвэр: олон төрлийн тээврийн хэрэгслээр зорчих
- Аялал жуулчлал: хот, хөдөө аялах, аймаг, сум нэрлэх
- Зочлох: айлд зочлох, мэндлэх
- Банк: мөнгө солих, шилжүүлэх, гүйлгээ хийх
- Үсчин: үсээ засуулах, угаалгах, будуулах
- Шуудан: захиа явуулах, шуудангийн марк, дугтуй авах
- Цаг агаар: дөрвөн улирлын онцлог
- Байгалийн гамшиг: байгалийн үзэгдэл, үер ус
- Хөдөө явах: уул ус, мод ургамал, цэцэг ногоо
- Улаанбаатар хот: хотын дурсгалт газрууд, музей, кинотеатр
- Эмнэлэг: өвчний нэр, эмчид үзүүлэх, шинжилгээ өгөх
- Зочид буудал: Улаанбаатар хотын зочид буудлууд, өрөө захиалах
- Спорт: спортын олон төрөл, дуртай спорт
- Нисэх буудал: нисэх буудал явах, хүн тосох, гаргаж өгөх
- Үндэсний баяр: Наадам тэмдэглэх, эрийн гурван наадам
- Цагаан сар: золгох, хүндлэх ёстой холбоотой үг хэллэг
- Таван хошуу: мал, малын нас, зүс
- Хоол унд, цагаан идээ: хоол ундны төрөл зүйл, цагаан идээг нэрлэх
- Хүний бие эрхтэн: хүний биеийн хэсгийг нэрлэх
- Өнгө: өнгө заасан тэмдэг нэр
- Ааш зан: хүний ааш зан, төлөв байлдыг илэрхийлсэн үг хэллэг
- Зөвшөөрөл авах: орох гарах, авах өгөх, явах ирэх, суух босох гэх мэт зөвшөөрөл авах
- Ерөөх, баяр хүргэх, талархах
- Номын сан: ном хайх, захиалах, танхимд унших, номыг гэрээр зээлж авах
- Үзвэр үйлчилгээ: музей, театр, кинотеатр явах
- Монгол ёс заншил: мэндлэх, хүндлэх, зочлох

Хамгийн олон давтамжтай үгсийг энд дурдсан сэдэвтэй хэр уялдаж байгааг тогтоосон бөгөөд багш, ажиллах, авах, нэр, оюутан, уух, бичих, анги, асуух, гэр, дуртай, одоо, ирэх, маргааш, сайхан, ном, сайн, ойлгох, олон, манай, ямар, хэдэн, миний, дараа, мэдэх гэх мэт үгс хамгийн өндөр давтамжтай тохиолдож байна.

Энэхүү судалгааны үр дүнд анхан шатанд эзэмшвэл зохих үгийн нийт тоог 1663 гэж үзсэн бөгөөд анхан шатны М1 түвшинд 733 үг, М2 түвшинд 930 үг гэж тогтоосон болно.

Дүгнэлт

Монгол хэлийг хоёрдогч хэл болгон суралцагчийн үгийн сангийн мэдлэг чадварыг тодорхойлох судалгааны ажил өнөө хэр ховор байна. Бид энэхүү судалгаагаар монгол хэлний анхан шатанд зайлшгүй сурах үгийн жагсаалтыг боловсруулан гаргахдаа олон хэлний арга туршлагыг монгол хэлний онцлогтой харьцуулан судалсан болно.

Хоёрдогч хэл эзэмшихүй (SLA)-н онолд үгийн сан нь хэлний мэдлэг, үр дүнтэй харилцааны ур чадварыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг хэмээн үздэг. Тухайлбал, Крашений “Оролтын

таамаглал” (Input Hypothesis), Нэйшний “Үгийн сан сурахуйн орчил хүрээ” (Framework on vocabulary learning) зэрэг хэл эзэмшихүйн онолууд нь үгийн сангаар дамжуулан мэдээллийг хүлээн авч зөв ойлгох, үгийн санг тогтолцоотойгоор сурч эзэмшихийн ач холбогдлыг онцолсон байна.

Бидний энэхүү судалгааны үр дүнд монгол хэл сурч буй гадаадын суралцагчийн анхан шатанд эзэмшвэл зохих үгийн нийт тоог 1663 гэж тогтоосон бөгөөд үүнээс анхан шатны M1 түвшинд 733 үг, M2 түвшинд 930 үг гэж тогтоосон болно. Энэхүү судалгааны үр дүнг ашиглан гадаад оюутанд зориулсан монгол хэлний сурах бичиг, гарын авлагыг зохиохдоо ашиглах үгийн сангийн нөөц хязгаарын баримжаатай болж, чухам ямар ямар үгийг тухайн сургалтад заавал оруулах ёстой болохыг баримжаалан, сургалтын үр дүнг тогтолцоотойгоор сайжруулах практик ач холбогдолтой юм.

Ном зүй

1. Anber Nacera. 2010. Language learning strategies and the vocabulary size. Procedia Social and Behavioral Sciences 2.
2. David Hirsh, Paul Nation. 1992. What Vocabulary size is needed to read unsimplified texts for pleasure? Reading in a foreign language.
3. Hazenberg S., Hulstijn J.N. 1996. Defining a minimal receptive second-language vocabulary for non-native university students: an empirical investigation. Applied Linguistics.
4. Krashen, S. D. 1985. The Input Hypothesis: Issues and Implications. Longman.
5. Nation, I. S. P. 2001. Learning Vocabulary in Another Language. Cambridge University Press.
6. Norbert Schmitt. 2008. Review article: Instructed second language vocabulary learning. Language teaching research.
7. Norbert Schmitt. 2010. An introduction to Applied Linguistics. London. Routledge.
8. Paul Nation and James Coady. 1988. Vocabulary and reading. Vocabulary and language teaching. London: Routledge.
9. Paul Nation, Robert Waring. 1997. Vocabulary size, text coverage and word lists. Vocabulary: Description, Acquisition and Pedagogy. Cambridge University Press.
10. Paul Nation. 1993. Vocabulary size, growth, and use. Studies in Bilingualism. Vol.6.
11. Заяабаатар Д. нар. 2023. Олон улсын монгол хэлний шалгалтын тогтолцоо. Үндсэн аргачлал. Улаанбаатар

Abstract

The teaching of Mongolian as a second language to foreign students and learners has a long history. Despite the publication of numerous textbooks and manuals for Mongolian language instruction, there remains a scarcity of comprehensive Mongolian vocabulary resources and research on vocabulary proficiency across different levels. This article addresses this gap by determining the vocabulary size of beginner-level learners of Mongolian as a second language. Our findings yielded a list of 733 words at the beginner M1 level and 930 words at the M2 level, totaling 1,663 words. For further details on the methodology and theoretical framework used in constructing this list, readers are referred to the full article.

Талархал

Энэхүү судалгааны ажлыг 2021-2023 онд Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Сангийн санхүүжилтээр МУИС-ийн профессор Д.Заяабаатарын удирдаж хэрэгжүүлсэн “Монгол хэлний стандарт шалгалт” инновацын төслийн судлаачдын багийн ажлын үр дүнд тулгуурлан гүйцэтгэв. Тус өгүүллийг хянан тохиолдуулсан “Монгол судлал“ сэтгүүлийн редакцын зөвлөлийн гишүүдэд талархал илэрхийлье.

Хавсралт. М1 түвшний үгийн жагсаалт

1. аав
2. ааруул
3. аарц
4. ав-
5. авар-
6. австрали
7. автобус
8. автобусны буудал
9. авчир-
10. агаар
11. адил
12. адуу
13. ажил
14. ажилла-
15. ажилтан
16. ажилчин
17. ази
18. ай-
19. айл
20. айраг
21. алдаа
22. алим
23. алх-
24. алчуур
25. аль
26. ам
27. амар-
28. амархан
29. америк
30. амжилт
31. амралт
32. амт
33. амьдар-
34. амьтан
35. анги
36. англи
37. арав
38. аравдугаар сар
39. арагш
40. арал
41. арван нэгдүгээр сар
42. арван хоёрдугаар сар
43. аргын тоолол
44. ард (хойно)
45. ариун цэврийн өрөө
46. архи
47. асуу-
48. асуулт
49. африк
50. ах
51. ахмад
52. ач
53. ашигла-
54. аяга
55. аял-
56. аялагч
57. аялал
58. аяллын хуваарь
59. баг
60. бага
61. багийн ахлагч
62. багш
63. бай-
64. байр
65. байцай
66. байшин
67. бал
68. баллуур
69. банк
70. бараг
71. бариа
72. барилгачин
73. баруун
74. барь-
75. бас
76. баян
77. баяр
78. баярла-
79. баярлалаа
80. баяртай
81. би
82. бид
83. бие
84. бие засах газар
85. билгийн тоолол
86. битгий
87. битүүн
88. бич-
89. биш
90. богино
91. бод-
92. бол-
93. болгоомжтой
94. боов
95. боорцог
96. бор
97. бороо
98. бос
99. ботго
100. бөгж
101. бөмбөг
102. бөх
103. бугуйн цаг
104. будаа
105. буйдан
106. буруу
107. бусад
108. буу-
109. бууз
110. буц-
111. бүгд
112. бүжиг

113. бүжиглэ-
114. бүжигчин
115. бүр
116. бүрхэг
117. бүс
118. бүтэн сайн
119. бүү
120. бүх
121. бэ /вэ
122. бэлд-
123. бэлэг
124. бэлэглэ-
125. бэлэн
126. бээлий
127. бялуу
128. бяслаг
129. виз
130. вьетнам
131. гадаад
132. гадил
133. гадна
134. газар
135. газрын зураг
136. гайхалтай
137. гал
138. гал тогоо
139. галт тэрэг
140. гар
141. гар-
142. гар бөмбөг
143. гар утас
144. гараа
145. гаруй
146. герман
147. гийгүүлэгч
148. гоймон
149. гол
150. голдуу
151. гольф
152. гөлөг
153. грамм
154. гуанз
155. гудамж
156. гурав
157. гурав дахь өдөр
158. гуравдугаар сар
159. гурил
160. гутал
161. гуч
162. гүй-
163. гүүр
164. гэнэт
165. гэр
166. гэр бүл
167. гэрлэ-
168. давт-
169. давхар
170. дага-
171. дал
172. далай
173. дар-
174. дараа
175. дарга
176. дарс
177. дасгал
178. дасгалжуулагч
179. дахин
180. дахь / дэх
181. докторант
182. долоо
183. долоодугаар сар
184. доод
185. доор
186. доош
187. дотно
188. дотоод
189. дотор
190. дөрөв
191. дөрөвдэх өдөр
192. дөрөвдүгээр сар
193. дөч
194. дугаар
195. дугаар / дүгээр
196. дулаан
197. дунд
198. дуу
199. дууд-
200. дуул-
201. дуус-
202. дуучин
203. дүрэм
204. дүү
205. дүүрэн
206. дэвтэр
207. дэлгүүр
208. дэлхий
209. дэргэд
210. дээд
211. дээл
212. дээр
213. дээш
214. европ
215. ер (тоо)
216. ерөнхий сайд
217. ерөнхийлөгч
218. ес
219. ёс
220. ёсгүй
221. есдүгээр сар
222. ёстой
223. жаахан
224. жагсаалт
225. жар
226. жигнүүр
227. жигнэмэг
228. жигнэх
229. жижиг

230. жижүүр
231. жил
232. жимс
233. жолоод-
234. жолооч
235. жорлон
236. жуулчны бааз
237. жүрж
238. за
239. заа-
240. зав
241. завсарла-
242. загас
243. зайрмаг
244. залуу
245. залхуу
246. зам
247. заншил
248. зар-
249. зарим
250. заримдаа
251. зарла-
252. зарцуул-
253. зас-
254. зах
255. захиа
256. захиал-
257. захирал
258. зогс-
259. золго-
260. зочин
261. зочны өрөө
262. зөв
263. зөвлө-
264. зөвхөн
265. зөөгч
266. зөөлөн
267. зун
268. зур-
269. зураг
270. зурагт
271. зургаа
272. зургаадугаар сар
273. зуу
274. зүгээр
275. зүрх
276. зүүлт
277. зүүн
278. зээ
279. ид-
280. идээ
281. ийм
282. ингэ-
283. инээ-
284. ир-
285. ирээдүй
286. итгэ-
287. их
288. их дэлгүүр
289. ишиг
290. кассчин
291. килограмм
292. километр
293. кино
294. компьютер
295. лам
296. лаос
297. литр
298. лууван
299. магадгүй
300. магистрант
301. майхан
302. мал
303. малгай
304. малчин
305. манаач
306. манан
307. маргааш
308. март-
309. мах
310. маш
311. машин
312. медаль
313. менежер
314. метр
315. миллиметр
316. миний
317. минь
318. минут
319. могой
320. мод
321. морины уралдаан
322. морь
323. мөн
324. мөнгө
325. мөндөр
326. мөс
327. музей
328. муу
329. муур
330. муухай
331. мэд-
332. мэдээ
333. мэндэл-
334. мэргэжил
335. мэргэжилтэн
336. мянга
337. наадам
338. надад
339. найз
340. найм
341. наймдугаар сар
342. нам
343. намайг
344. намар
345. нар
346. нас

347. ная
348. нийслэл
349. нимбэг
350. нимгэн
351. нис-
352. нислэг
353. ногоо
354. ногоон
355. ноднин
356. ном
357. нохой
358. нөгөө
359. нөгөөдөр
360. нөхөр
361. нуруу
362. нуур
363. нүд
364. нүүр
365. нэг
366. нэгдэх өдөр
367. нэгдүгээр сар
368. нэм-
369. нэр
370. нээ-
371. овьёос
372. одоо
373. ойлго-
374. оймс
375. ол-
376. олимп
377. он
378. онгоц
379. ор-
380. ор
381. орой
382. оройн хоол
383. оролц-
384. ороолт
385. орос
386. орц
387. орчим
388. орчуул-
389. охин
390. оч-
391. оюутан
392. өвгөд
393. өвд-
394. өвөл
395. өвөө
396. өг-
397. өглөө
398. өглөөний цай
399. өдөр
400. өдрийн хоол
401. өлгө-
402. өлс-
403. өмд
404. өмнө
405. өмс-
406. өнгө
407. өнгөрсөн
408. өндөг
409. өндөр
410. өнөө
411. өнөөдөр
412. өөр
413. өргөн
414. өргөст хэмх
415. өрөө
416. өчигдөр
417. паспорт
418. польш
419. ресторан
420. саван
421. сагсан бөмбөг
422. сайн
423. сайхан
424. салхи
425. салхил-
426. самар
427. самбар
428. сана-
429. сандал
430. сантиметр
431. сар
432. саримс
433. сая
434. солонгос
435. соль-
436. сонгино
437. сонго-
438. сонин
439. сонирхол
440. сонс-
441. спорт
442. судал-
443. судлаач
444. сур
445. сур-
446. сурагч
447. сургууль
448. суу-
449. сүү
450. сэдэв
451. сэл-
452. сэр-
453. сэрүүн
454. та
455. та нар
456. тааз
457. тав
458. тавдахь өдөр
459. таваг
460. тавдугаар сар
461. тавь
462. тавь-
463. тайван

464. тайл-
465. тайлбарла-
466. такси
467. талх
468. тамирчин
469. тань-
470. тараг
471. тарган
472. тариачин
473. тасал-
474. тасалбар
475. тат-
476. театр
477. теллер
478. теннис
479. тив
480. тийм
481. тогло-
482. тоглоом
483. тогоо
484. толгой
485. том
486. том өрөө
487. тоо
488. тоол-
489. торго
490. тос
491. төв талбай
492. төгс-
493. төмс
494. тугал
495. тусал-
496. тухай
497. түвшин
498. түр
499. түүний
500. түүнд
501. түүх
502. тэг
503. тэг-
504. тэд
505. тэдгээр
506. тэмдэг
507. тэмцээн
508. тэмээ
509. тэнгэр
510. тэнд
511. тэр
512. тэрбум
513. тээш
514. угаа-
515. угаалгын өрөө
516. удаа
517. удаан
518. уйл-
519. улаан
520. улаан лооль
521. уламжлалт
522. улирал
523. улмаас
524. улс
525. уна-
526. унага
527. унгар
528. ундаа
529. унт-
530. унш-
531. урагш
532. уралдаан
533. урд
534. уржигдар
535. урт
536. ус
537. усан үзэм
538. утас
539. уу-
540. уу/үү, юу/юү?
541. уул
542. уулз-
543. ууц
544. уучил-
545. учир
546. үг
547. үгүй
548. үз-
549. үзэг
550. үзэм
551. үндэсний
552. үнэ
553. үнэн
554. үнэр
555. үр
556. үргэлж
557. үс
558. үсчин
559. үсэг
560. үүл
561. үүргэвч
562. үхэр
563. франц
564. хаа-
565. хаалга
566. хаана
567. хаашаа
568. хааяа
569. хавар
570. хагас
571. хагас сайн
572. хажууд
573. хай-
574. хайр
575. халуун
576. хамар
577. хамт
578. хана
579. ханын цаг
580. хар

581. харь-
582. харандаа
583. харанхуй
584. харва-
585. харин
586. хариул-
587. хатуу
588. хая-
589. хаяг
590. хиам
591. хий-
592. хичээл
593. хоёр
594. хоёрдахь өдөр
595. хоёрдугаар сар
596. хож-
597. хожигд-
598. хойно
599. хойш
600. хол
601. хонь
602. хоол
603. хоолло-
604. хооронд
605. хоосон
606. хот
607. хөгжимчин
608. хөгшин
609. хөдөө
610. хөл
611. хөл бөмбөг
612. хөнгөн
613. хөргөгч
614. хөрш
615. хөтөч
616. хөшиг
617. хуваа-
618. худалдагч
619. хулгайл-
620. хурга
621. хурдан
622. хуудас
623. хуурай
624. хуучин
625. хүйтэн
626. хүлээ-
627. хүн
628. хүнд
629. хүр-
630. хүртэл
631. хүрэм
632. хүс-
633. хүүхэд
634. хэвт-
635. хэд
636. хэдэн
637. хэзээ
638. хэл
639. хэл-
640. хэм
641. хэмжээ
642. хэн
643. хэрхэн
644. хэрэв
645. хэрэглэ-
646. хэрэгтэй
647. хэрэлд-
648. хэсэг
649. хэцүү
650. хямд
651. хятад
652. цаг
653. цагаан
654. цагаан сар
655. цагдаа
656. цад-
657. цай
658. цамц
659. цанга-
660. цас
661. цонх
662. цохь-
663. цүнх
664. цэвэрлэ-
665. цэвэрлэгч
666. цэг
667. цэлмэг
668. цээжил-
669. чад-
670. чанамал
671. чанга
672. чех
673. чи
674. чиний
675. чих
676. чихэр
677. чөлөөгүй
678. чөлөөтэй
679. чүдэнз
680. шал
681. шалга-
682. шалгалт
683. шар
684. шат
685. шатар
686. шийд-
687. шинэ
688. шинэ жил
689. ширхэг
690. ширээ
691. шоколад
692. шохой
693. шөнө
694. шууд
695. шуудан
696. шуур-
697. шуурга

698. шүү
699. шүүгч
700. шүүгээ
701. шүүс
702. эгч
703. эгшиг
704. эдгээр
705. элсэн чихэр
706. эмнэлэг
707. эмч
708. эмэгтэй
709. эмээ
710. энгийн
711. энд
712. энэ
713. эргэ-
714. эрт
715. эрэгтэй
716. эхэл-
717. ээж
718. ээмэг
719. юм
720. юу
721. яа-
722. яагаад
723. яар-
724. яасан
725. яв-
726. ягаан
727. ядар-
728. ямаа
729. ямар
730. япон
731. яриа
732. ярилц-
733. ярь-

М2 түвшний үгийн жагсаалт

1. аалз
2. ааш
3. авагч
4. авга
5. авдар
6. авьяас
7. агшаагч
8. агшин
9. адал
10. адуучин
11. ажигла-
12. ажилсаг
13. аз
14. азарга
15. азтан
16. аймаг
17. аймхай
18. аймшиг
19. албан
20. алга
21. алд- (хаях, гээх)
22. алт
23. алтан
24. алхам
25. амар (амгалан)
26. амж-
27. амс-
28. амтал-
29. амтат
30. амь
31. амьд
32. амьдрал
33. амьсгал
34. ан
35. анааш
36. ангилал
37. анд
38. анх
39. анхаар-
40. анхаарал
41. анчин
42. араатан
43. арай
44. арван
45. арга
46. ард
47. ариун
48. арслан
49. арч-
50. арьс
51. асаа-
52. асар-
53. асга
54. ахлагч
55. ахлах
56. ач-
57. ачаа
58. аштай
59. аюул
60. ая (дуу)
61. аян
62. ба
63. баавгай
64. бааз
65. баасан
66. баатар
67. багана
68. багт-
69. байгаль

70. байгуул-
71. байгууллага
72. байдал
73. байлгүй
74. байнга
75. байрлуул-
76. балет
77. банш
78. бар
79. бараа
80. бардам
81. барилга
82. баримтат
83. бариул
84. баталгааж-
85. баяж-
86. биел-
87. бий
88. билет
89. билиг
90. билээ / билүү
91. бирж
92. бич
93. бичиг
94. бичлэг
95. бичмэл
96. богд
97. бодол
98. бокс
99. болго-
100. болгоомжил-
101. болжмор
102. бололтой
103. боломжтой
104. болон
105. боо-
106. бохир
107. бохь
108. бөглө-
109. бөгөөд
110. бөгс
111. бөжин
112. бөөрөнхий
113. бөхий-
114. бугуйвч
115. буд-
116. будаг
117. булан
118. бут
119. буу-
120. буудал
121. буур
122. бух
123. буцал-
124. буюу
125. бүдүүн
126. бүл
127. бүлэг
128. бүлээн
129. бүртгүүл-
130. бүртгэ-
131. бүртгэл
132. бүсгүй
133. бүтэн
134. бүтээ-
135. бүтээгдхүүн
136. бүтээл
137. бэлтгэл
138. бэх
139. бямба
140. бяц
141. гадаа
142. гадуур
143. гайх-
144. галерей
145. ганц
146. гараг
147. гарга-
148. гарц
149. гахай
150. гашуун
151. гитар
152. гишгэ-
153. говь
154. гоё
155. гомд-
156. гуай
157. гуй-
158. гулга-
159. гуниг
160. гуч (ач)
161. гуя
162. гүзээлзгэнэ
163. гүн
164. гүрвэл
165. гүү
166. гэ-
167. гэвч
168. гэдэс
169. гэмт-
170. гэрэл
171. гэтэл
172. даа
173. даа-
174. даавуу
175. даалгавар
176. даам
177. даар-
178. даатгал
179. даашинз
180. дав-
181. даваа (гараг)
182. давс
183. давталт
184. давтлага
185. давхи-
186. дагавар

187. дадлага
188. дал (мөр)
189. далбаа
190. дамж-
191. дамжуул-
192. дандаа
193. данс
194. дараал-
195. дармал
196. дас-
197. дахиад
198. дахь-
199. дизайнер
200. долоо-
201. доогуур
202. дор
203. доромжил-
204. дотогш
205. дотуур
206. дохь-
207. дөрвөлжин
208. драм
209. дугуй
210. дугуйл-
211. дугуйлан
212. дулаал-
213. дулаар-
214. дундуур
215. дур
216. дурсамж
217. дуртай
218. дутуу
219. дуугар-
220. дуудлага
221. дуурь
222. дух
223. дүгээр
224. дүлий
225. дүн
226. дүр
227. дүрс
228. дүрсэл-
229. дүүр-
230. дүүрэг
231. дэлгэрэнгүй
232. дэлгэц
233. дэр
234. дээвэр
235. дээгүүр
236. дээрх
237. ерөө
238. ёслол
239. жагс-
240. жарга-
241. жаргал
242. жигнэ-
243. жижиглэ-
244. жим
245. жин
246. жирэмсэн
247. жишиг
248. жишээ
249. жолоо
250. жор
251. жуулчин
252. жүжиг
253. жүжигчин
254. заавал
255. заал
256. заан
257. заваан
258. загна-
259. зай
260. залга-
261. залуучууд
262. зан
263. зар
264. зардал
265. заримдаг
266. зарлал
267. засвар
268. засмал
269. засуул-
270. захиалагч
271. захиалга
272. захидал
273. захь-
274. зов-
275. зовлон
276. зогсоол
277. зод-
278. зоог
279. зориг
280. зорилго
281. зориул-
282. зорчигч
283. зохио-
284. зохиол
285. зохиолч
286. зөвлөгөө
287. зөвшөөр-
288. зөвшөөрөл
289. зөгий
290. зөө-
291. зөрч-
292. зугаал-
293. зугт-
294. зузаан
295. зулзага
296. зураач
297. зурагчин
298. зуруул-
299. зуслан
300. зуун
301. зуур-
302. зүг
303. зүй

304. зүйл
305. зүлэг
306. зүс-
307. зүү-
308. зүүд
309. зүүдэл-
310. зэрэг
311. зээл
312. ижил
313. ийм учраас
314. иймд
315. иймээс
316. ийш
317. илгээ-
318. илүү
319. индүү
320. инженер
321. интернет
322. инээ-
323. инээд
324. инээдэм
325. иргэн
326. итгэл
327. ихэвчлэн
328. ихэнх
329. ихэр
330. ич-
331. карт
332. километр
333. компани
334. кофе
335. л
336. лаа
337. лавлах
338. луужин
339. лхагва
340. маамуу
341. магад
342. магт-
343. май
344. малла-
345. манай
346. манд-
347. материал
348. морил-
349. мөлх-
350. мөнгөн
351. мөнх
352. мөөг
353. мөр
354. мөрөөд-
355. мөчир
356. мужаан
357. мууд-
358. мэдрэл
359. мэдрэхүй
360. мэдээж
361. мэдээл-
362. мэдээлэл
363. мэнд
364. мэндчилгээ
365. мягмар
366. наагуур
367. наана
368. нааш
369. навч
370. нагац
371. найд-
372. найзал-
373. найр
374. найрлага
375. намаржаа
376. нарийн
377. настан
378. нийл-
379. нийт
380. нисгэгч
381. ногоочин
382. ноён
383. нойр
384. нойтон
385. номын сан
386. ноолуур
387. нор-
388. нөөц
389. нөх-
390. нөхөрлө-
391. нөхцөл
392. нутаг
393. нуу-
394. нүү-
395. нүх
396. нэвтрүүлэг
397. нэвтэр-
398. нэгж
399. нэм-
400. нэмэгд-
401. нэмэлт
402. нэрлэ-
403. нэрс
404. нэхэмжил-
405. нэхэмжлэгч
406. нэхэмжлэх
407. нээ-
408. нээлт
409. ням
410. нярай
411. овог
412. од
413. ой
414. ойр
415. ойрт-
416. олон
417. онгой-
418. оноо
419. онц
420. оо

421. ордон
422. оролд-
423. орон
424. оруул-
425. орчуулагч
426. отгон
427. өвдөг
428. өвөлжөө
429. өвс
430. өвчин
431. өгс-
432. өгүүлбэр
433. өдөржин
434. өдөрлөг
435. өлгүүл-
436. өлгүүр
437. өмнөд
438. өнгөр-
439. өөрсдөө
440. өөх
441. өргөө
442. өс-
443. пүрэв
444. регистр
445. саа-
446. саарал
447. сав
448. савх
449. сагс
450. сайд
451. сайжир-
452. сайн дурын ажилтан
453. салбар
454. сам
455. самна-
456. сан
457. санаа
458. санагд-
459. санал
460. сарнай
461. сахал
462. саяхан
463. соёл
464. сойз
465. солиул-
466. солонго
467. сонгодог
468. сонголт
469. сондгой
470. сонирх-
471. сонсогч
472. сөрөг
473. сувилагч
474. сул
475. сум
476. сунга
477. суралцагч
478. сурга-
479. сургалт
480. сурталчилгаа
481. суудал
482. сууц
483. сүм
484. сүр
485. сүүл
486. сэл-
487. сэргэлэн
488. сэрүүхэн
489. сэрээ
490. сэтгүүл
491. сэтгүүлч
492. сэтгэл
493. таа-
494. таалагд-
495. таар-
496. тавилга
497. тавиур
498. тавтай
499. таг
500. тагтаа
501. тайлбар
502. тайр-
503. тайруул-
504. тал
505. талаар
506. талархах-
507. талбай
508. тамга
509. тамир
510. тамхи
511. тан
512. танай
513. танайхан
514. танилц-
515. танилцуулга
516. танхим
517. тар-
518. тараа-
519. тариа
520. тариалан
521. тарь-
522. тасаг
523. тасалгаат
524. тасар-
525. тахиа
526. тий тий
527. тийм учраас
528. тиймд
529. тиймээс
530. тийш
531. товч
532. тог
533. тоглолт
534. тоглуул-
535. тогооч
536. тод
537. тодорхойлолт

538. тойр-
539. толь
540. тоос
541. тоот
542. тооц-
543. тооцоо
544. тор
545. тос-
546. тосгон
547. тохир-
548. тохируул-
549. тохой
550. төв
551. төгрөг
552. төгсгөл
553. төлөвлө-
554. төлөгд-
555. төлөгч
556. төлөө
557. төмөр
558. төөр-
559. төр-
560. төрөл
561. тулга
562. тулд
563. туранхай
564. тусгай
565. тусламж
566. тусч
567. тутам
568. туулай
569. тушаал
570. түгжрэл
571. түймэр
572. түл-
573. түлхүүр
574. түргэн
575. түү-
576. түшээ
577. тэгвэл
578. тэгш
579. тэгээд
580. тэжээ-
581. тэмдэглэ-
582. тэнцүү
583. тэнэг
584. тэрэг
585. тээвэр
586. угаалга
587. угаалга-
588. угт-
589. уд-
590. удирдлага (зурагтын)
591. уйд-
592. уйтгарла-
593. улай-
594. улам
595. унаа
596. унд
597. унтар-
598. унтлага
599. унтраа-
600. уншигч
601. урагшаа
602. урамшуулал
603. уран
604. урга-
605. ургамал
606. урдуур
607. уржнан
608. урилга
609. урлаг
610. урс-
611. урь-
612. урьд
613. усал-
614. устга-
615. утаа
616. утга
617. уур
618. уурла-
619. уут
620. уучлаарай
621. уушги
622. учиртай
623. уянга
624. үд-
625. үдэш
626. үдэшлэг
627. үе
628. үер
629. үеэл
630. үзвэр
631. үзлэг
632. үзүүл-
633. үзэгч
634. үзэсгэлэн
635. үйлдвэр
636. үйлдвэрлэ-
637. үйлчилгээ
638. үйлчлүүлэгч
639. үлгэр
640. үлд-
641. үлдээ-
642. үндэс
643. үндэстэн
644. үнс-
645. үнэг
646. үнэлгээ
647. үнэмлэх
648. үнэрлэ-
649. үнээ
650. үргэлжил
651. үсэр-
652. үүд
653. үүрд

654. хаагуур
655. хаалт
656. хаан
657. хаана ч
658. хаанаас ч
659. хаашаа ч
660. хаваржаа
661. хавтас
662. хавь
663. хага
664. хагал-
665. хадгал-
666. хажуу
667. хайл-
668. хайртай
669. хайрцаг
670. хал-
671. халбага
672. халиун
673. халтир-
674. халууц-
675. хамгаал-
676. хамгаалагч
677. хамгийн
678. хамтар-
679. хамтлаг
680. хан
681. хангай
682. ханиад
683. ханш
684. харагд-
685. харамла-
686. харилцаа
687. хариулт
688. харуул
689. харь
690. харьцуул-
691. хас-
692. хат-
693. хатан
694. хацар
695. хашаа
696. хивс
697. хийд
698. хичээ-
699. хичээллэ-
700. хог
701. ходоод
702. хоёул
703. хойгуур
704. хойд
705. хойтон
706. хойшоо
707. холбо-
708. холбогдол
709. холбоо
710. холь-
711. хоно-
712. хоног
713. хонх
714. хоолой
715. хор
716. хоригло-
717. хороо
718. хороолол
719. хорхой
720. хос
721. хотхон
722. хоцор-
723. хошуу
724. хөв-
725. хөвгүүд
726. хөгжилтэй
727. хөгжим
728. хөгжөөнт
729. хөдөл-
730. хөлд-
731. хөлдүү
732. хөмсөг
733. хөндлөн
734. хөнжил
735. хөө-
736. хөөрхөн
737. хөргөгч
738. хөрс
739. хөтөл-
740. хөтөлбөр
741. хөх
742. хөхөө
743. хөхтөн
744. хөшөө
745. хуваарь
746. хувилбар
747. хувцас
748. хувцасла-
749. хувьцаат
750. хуга
751. хугал-
752. хугар-
753. хугацаа
754. худал
755. худалд-
756. худалдаа
757. хулгай
758. хулгайч
759. хулгана
760. хун
761. хураа-
762. хураамж
763. хурал
764. хурд
765. хурдал-
766. хурим
767. хуруу
768. хутга
769. хуул-
770. хууль

771. хуур
772. хуур-
773. хуурга
774. хуушуур
775. хүйс
776. хүйтэр
777. хүмүүс
778. хүндэл-
779. хүндэт
780. хүндэтгэ-
781. хүнс
782. хүргэ-
783. хүргэлт
784. хүрээлэн
785. хүсэл
786. хүү
787. хүүхэлдэй
788. хүч
789. хэвлэ-
790. хэвлэл
791. хэд ч
792. хэддүгээр
793. хэдийд
794. хэдүүл
795. хэзээ ч
796. хэлбэр
797. хэмж-
798. хэн ч
799. хэр
800. хэрвээ
801. хэрч-
802. хэрэг
803. хэрэглэл
804. хэрэгсэл
805. хэрэм
806. хэрээ
807. хэчнээн
808. хямдар-
809. хямдралтай
810. цаагуур
811. цаазат
812. цаана
813. цаас
814. цааш
815. цалин
816. цана
817. царай
818. цахилгаан
819. цахим
820. цахь-
821. цирк
822. цоо
823. цоож
824. цоч-
825. цөл
826. цөөн
827. цөцгий
828. цув
829. цуг
830. цугла-
831. цуглар-
832. цус
833. цуцал-
834. цэвэр
835. цэнгэл
836. цэнхэр
837. цэрэг
838. цэцэг
839. цэцэрлэг
840. цээж
841. ч
842. чадвар
843. чамайг
844. чамд
845. чана-
846. чарга
847. чацаргана
848. чиг
849. чиглэл
850. чийдэн
851. чимх-
852. чимэг
853. чимээ
854. чоно
855. чөлөө
856. чулуу
857. шав-
858. шавар
859. шавж
860. шавь
861. шагай
862. шагна-
863. шагнал
864. шар-
865. шарла-
866. шат-
867. шахам
868. шид-
869. шил
870. шилдэг
871. шилжүүл-
872. шингэн
873. ширүүн
874. шороо
875. шөл
876. шувуу
877. шугам
878. шударга
879. шулуун
880. шүд
881. шүлс
882. шүлэг
883. шүт-
884. шүүр-
885. шүүх
886. шүхэр
887. эвд-

888. эвх-
889. эвэр
890. эгнээ
891. эд
892. эдгэ-
893. эелдэг
894. эзэл-
895. эзэн
896. элс
897. элс-
898. элэг
899. эм
900. эмгэнэлт
901. эмчил-
902. эр
903. эрвээхэй
904. эрдэмтэн
905. эрүү
906. эрхий
907. эрхтэн
908. эрхэм
909. эрэг
910. эсвэл
911. эсэргүүц-
912. эх
913. эхнэр
914. эцэг
915. эцэс
916. ээлж
917. юу ч
918. явган
919. явдалт
920. яг
921. ядаргаа
922. ядуу
923. ялаа
924. ялагч
925. ялалт
926. ялга-
927. ямар ч
928. яргуй
929. ярилцлага
930. яс